

Ж.ЦЭВЭЭН МОНГОЛЫН БОЛОВСРОЛД

Б.Пунсалдулам. Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч утга: Нэрт эрдэмтэн Ж.Цэвээний монголд орчин цагийн сургууль боловсролыг үүсгэн байгуулахад оруулсан хувь нэмрийн тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: Сургууль, боловсрол, хөтөлбөр, дүрэм, стандарт

Ж.Цэвээн монголын ард түмний үр хүүхдийг сургах, орчин үеийн боловсрол, шинжлэх ухааны сургуулийн үндэс суурийг тавигчдын нэг билээ. Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлсэд оруулсан түүний нөр их хөдөлмөрийг Олноо Өргөгдсөн Монголын улсын үе/1911-1917он/, Ардын засгийн жилүүдийн үе/1921-1932 он/ дэх үйл ажиллагаа хэмээн хуваан авч үзэж болохоор байна.

Ж.Цэвээн Монголд 1911 оны үеэр ирж үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үйл явцад идэвхтэй оролцохын хамт орчин цагийн иргэний боловсролын эх үүсгэлийг тавилцсан билээ. Тэрээр Монголын 1911 оны үндэсний хувьсгалын удирдагчдын нэг, Гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд чин ван Ханддорж нарын хамт санаачлан иргэний эрдэм мэдлэг эрхлэн сургах анхны бага сургуулийг 1912 оны III сарын 24-нд 47 хүүхэдтэйгээр байгуулсан байна. Энэхүү анхны бага сургуульд Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён ханы аймгууд ба Их шавь, Барга хошуудаас хүүхдүүд суралцаж байжээ.

Үүний дараа буюу 1912 оны III сарын 30-нд Ж.Цэвээн Гадаад яаманд өргөсөн бичигтээ “Ван өршөөж” түмэн монголчуудыг эрдэм дор нэвтрүүлэн аж байдлыг боловсруулан хүмүүжүүлэх зэргийн явдлыг өчүүхэн буриад Цэвээн надад дор бодомжилтугай хэмээн тушаасан билээ... Гадаадын олон хүчирхэг улсын хамаг чадал ану гагцхүү элдэв ухааны эрдэмд нэвтрэлцэн... зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ. Гадаад улсын сургууль гурван зэрэг бөгөөд дороос үзэх нь улам бүр гүн дэлгэрэнгүй болсоор амой... төрөлх хэлний ухаан, тоо бодлого, хэмжих зурах ухаан, дүрст бодисыг элдэвчлэн шинжлэх ухаан, ертөнц дэлхийн байдал... дээр дурдсан нийт ухааны сургуулиас гадна ... цэргийн сургууль, эмчлэх сургууль, багшийн сургууль, урлах сургууль, уурхай нээх, худалдаа хийх, тарианы аж, мал аж, сүү тосны аж гэх мэт ямагт нэгэн зүйл ухааныг эрхэлсэн сургууль маш олон болой... учир иймийн тулд хүсэх ану: гээд Да Хүрээнд дорд сургууль байгуулах, гадаад хэлнээс орос, хятад хэлийг сонгон үзүүлэх, дөрвөн аймагт сургууль байгуулах, сүү, тос, мал аж

сайжруулах сургууль байгуулах, ухаан бүрийн дэвтрүүдийг монголоор зохиолгох ..." гэжээ.(1.75) Ийнхүү түүний гаргасан саналын дагуу арга хэмжээ авч сургуулийг олноор байгуулж сургалтын төлөвлөгөө, дүрэм, заах зүйлийн хөтөлбөр үзэх ном, сурах бичигтэй болох ажил эрчимжээ. Тухайлбал 1912-1913 оны хооронд улсын хэмжээгээр бага сургууль 60 гаруйг байгуулж, эрэгтэй хүүхдүүдийг анги (баян, хоосон Б.П) ялгаварлахгүй сургаж байжээ.

Ж.Цэвээн бага дунд сургууль болон багш нарыг бэлтгэх сургууль байгуулахад гар бие оролцон өөрөө хичээл заахын зэрэгцээ Гадаад яамны дэргэд байгуулагдсан орчуулагч хэлмэрчний сургуульд Эрдэнэбатухан, Н.Т.Данчинов, Д.А.Абашеев, Гарма Ванпилов нарын хамт уригдан багшилж байв.

Олноо Өргөгдсөн Монгол улсын үед сургууль боловсролын шинэтгэл хийж, төрийн сургуулийн тогтолцоог (бага, дунд, дээд сургуулийн дүрэм гаргаж) бий болгохыг зорьж зарим нэг арга хэмжээг хэрэгжүүлж байв. 1914 онд Гадаад яамнаас Богд хаанд "боловсрох, үүний тулд юуны өмнө сургуулийн хэргийг урьдал болгох бага, дунд, дээд зэргийн сургуулийн дүрэм ба их сургуулийн танхимын дүрэм хэмжээг дэс дараагаар хянан тогтоож байгуулах тухайг тайлбарласан нугалбар бичиг өргөжээ. Үүнийг төрөөс зохистой санал хэмээн хүлээн авч сургуулийн дүрэм зохиох ажлыг Богдын зарлигаар дараах хүмүүст даалгажээ. Үүнд: дэд сайд нягт билэгт гүн да лам Равдан, дэс түшмэл Бавуудорж, орчуулагч Ж.Цэвээн нар орсон байна.

Ингээд 1915 онд бага дунд сургуулийн дүрмийг боловсруулан гаргаж улсын дээд, доод хоёр хуралд оруулан хэлэлцүүлж батлуулжээ. Уул дүрэмд гурван шаттай сургуулийг байгуулж, бага сургуульд монгол үсгийн бичиг, шастир, энгийн тоо, монгол ба бусад олон газрын байдал төлөв, аж төрөхийг сайжруулах ёс, Монголын хураангуй түүх, биеийн тамир зэрэг хичээлийг, дунд сургуульд монгол бичиг, шастир, хууль цааз, орос, хятад, англи, франц хэл бичиг, тоо бодлого, газарзүй, дүрс бодис шинжлэх (физик, хэмжих зураг (геометр), эд боловсруулах, биеийн тамир зэрэг хичээлийг үзнэ хэмээн сургалтын стантарт, агуулгыг тогтоожээ.

Дунд сургууль нь бага сургуулийн нэгэн адил таван жилийн хугацаатай гэж заасан байна. Бага сургуулийг төгссөн сэцэн сэргэлэн хөвгүүдийг сонгон авч дунд сургуульд оруулах хэрэгтэй гэж дүрмэнд заажээ. Дүрэмд хан, ван,гүн, түшмэл, тайж баялаг ард ганц нэг хүн буюу хэд хэдэн хүн хоршиж, өөрийн хөрөнгө хүчээр

дунд сургууль байгуулах явдлыг дэмжинэ. Дунд сургууль төгсөгчдөд тэмдэгт бичиг олгон, дээд сургуульд оруулан сургах ба зарим онц сэргэлэн авъяастайгийн нь гадаад улсад илгээн сургах болно.

Бага сургуулийн дүрмээс үзвэл уг сургуулийг гурван маягаар байгуулах бодлоготой байв. Үүнд:

1. Улсын сангийн хөрөнгөөр байгуулагдан ажиллаж, улсын шууд харъяаны бага сургууль (Нийслэл Хүрээ, Маймаа хотын сургуулиуд)-ийг бүх талаар нь улсын сангаас хангана.

2. Орон нутгийн хүч хөрөнгөөр байгуулан ажиллах, орон нутгийн захиргаанд харъяалагдах бага сургууль

3. Хувийн хөрөнгө хүчээр байгуулагдан ажиллах бага сургууль. Хувийн хөрөнгө хүчээр сургууль байгуулагчид нь бага сургуулийн дүрмийг нарийн журамлан дагах, сургууль байгуулсан тухайгаа сургуулийн хэргийг захиран шийтгэх яаманд тодорхойлон мэдэгдэж зарлиг гуйн, айлтгаж зөвшөөрөл авч байх тухай үүрэгтэй.

Бага сургуулийн дүрэм нь 18, дунд сургуулийнх нь 5 бүлэг 29 зүйлтэй байжээ. Бага сургуулийн танхимд түшмэл, тайж ба харъяат албат нарын хүүхдийг 5 жил суралцуулах бөгөөд монгол үсэг сургаж, дараа нь сэцэн сэргэлэнийг нь сонгон авч, дунд зэргийн сургуулийн танхимд дэвшүүлэн оруулж монгол ба манж үсгийн бичиг шастир, хууль цааз, Орос, Хятад, Англи, Франц зэрэг улсын бичиг үсэг хэл, бодох сургууль, газар орон дэлхийн зураг, Монгол ба бусад улсын аж төрөх ёс ба түүх, дүрс бодис шинжлэх, хэмжих зурах, эд боловсруулах, биеийн судал, тамирыг сайжруулан боловсруулах зэрэг хичээл орно. Дунд сургууль мөн таван жил суралцна. Ийнхүү Монголд сургууль байгуулах ажил эхэлж, сургуулийн дүрэм хэмжээг боловсруулж, сургуульд үзэх ном сурах бичгийг зохиож орчуулах ажил эрчимжсэн байна.

Ж.Цэвээн тухайн үеийн монголын нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан шүүмжлэлт өгүүлэл бичихийн хамт сургалтын үндсэн агуулгыг улс орны өмнө тавигдаж буй шинэ түүхэн зорилтуудтай холбон үзэж, оюун ухааны хүмүүжил нь ёс суртхууны хүмүүжилтэй нягт холбоотой байх ёстой гэсэн сургалтын зарчмыг дэвшүүлэн тавьсан өгүүлэл бичиж “Шинэ толь”, “Нийслэл хүрээний сонин бичиг”-т “мухар огдой”, “Уулын өвгөн”, “Аюурзнаев”, “Бегзеев” зэрэг нууц нэрээр, бас нэргүйгээр бичиж хэвлүүлж байжээ.

Тухайлбал 1915 оны “Нийслэл Хүрээний сонин бичиг”-ийн №13-т “Хүний оюун хэдийгээр мэргэн түргэн болоод олж мэдсэн нь цаглашгүй боловч авир зан ааш явдал нь сайнгүй ахул эрдэмд сургасан хэрэг юун аж. Засгийг шинээр үүсгэн явуулахад хичээнгүй шударга үнэнч ариуныг гол багана болгож, улс төрд хэрэглэгдэх эрдмийн зүйлийг сургаваас сая зохино. Цагийг дагаж хуучин ёсыг халах ба шинээс сайныг олж сургах санаа гарч буй нь зүйтэй. Сонсвоос боловсон олон улсын сургуульд багш нар сурагч шавь нар юугаа эрхлэн мэдэж, авир зан ааш явдлыг удирдаж, аливаа муу авъяасыг нь баллан дарж, сайн авъяасыг сэргээн хөгжөөж нялх оюунд нь олон зүйлийн эрдэм зааж өгөх эрхийг бүрнээ эдэлнэ. Эрдэмтэн мэргэдийн шүүмжлэл дотор түмэн үнэн буй авч манай нийслэл Хүрээний газар үл ойшоогдоно. Зарим улсын үлэмж хүчирхэг болсон нь эд эрдэм хоёрын ач хэмээх тул монголчууд эс хичээвээс үл болмой” хэмээн сургамжлан өгүүлжээ.

Ардын засгийн жилүүдэд /1921-1931 он/ Ж.Цэвээн нь Намын Төв Хорооны болон Хянан байцаах комиссын гишүүн, Засгийн газрын Дотоод яамны нөхөрсөг зөвлөгч, Эдийн засгийн зөвлөлийн боловсронгуй гишүүн, Ардын гэгээрүүлэх яамны зөвлөх түшмэл, Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмт гишүүн, эрдэмтэн нарийн бичгийн дарга зэрэг нөр их ажлын хажуугаар багш нарыг бэлтгэх сургуульд багшлав, сурган хүмүүжүүлэх үйлсэд өөрийн мэдлэг оюунаа харамгүй зориулж явжээ. Тэрээр зөвхөн ардын засгийн жилүүдэд төдийгүй Олноо өргөгдсөн Монгол улсын үеэс л монгол түмний боловсрол, соёлын төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зорьж явсныг түүний зам мөр гэрчлэж байна.

- 1921 онд Монгол оронд хувьсгал ялж, улс орны аж ахуй соёлыг шинээр байгуулан хөгжүүлэх зорилтын дагуу сургуулиудыг байгуулах, ард түмний дотор соёлыг түгээн дэлгэрүүлэх ажил эхэлсэн байна.

1921 оны 8-р сарын 14-ны Ардын засгийн газрын сургуулийн танхим байгуулах тухай гаргасан тогтоол, 1921 оны намар засгийн газраас гаргасан “Дунд зэргийн сургуулийн дүрэм хэмжээ”-нүүд нь Олноо Өргөгдсөн Монгол улсын үед дэд сайд нягт билэгт гүн да лам Равдан, дэс түшмэл Бавуудорж, орчуулагч Ж.Цэвээн нарын зохиосон дүрмийн бага зэрэг засварлагдсан хувилбарууд байв. Энэхүү дүрмийг 1926, 1927 онд шинэчлэн баталж, үлэмж дэлгэрэнгүй хоёр дүрмийг баталжээ.

Ж.Цэвээн монголын анхан шатны сургуулиудад заах хичээлийн сурах бичгийг орчуулах, зохион бичих, хэвлэн нийтлэх, хамтран бүтээх ажлыг санаачлан журмын нөхдийн хамт их ажлыг бүтээжээ. Үүнд “Оюун түлхүүр” /1921/, “Зурхайн бодлого” /1922/, “Хүүхдийн журамтай сурах бичг” хоёр дэвтэр, “Хичээлийн бичиг” /1923/ дөрвөн дэвтэр ном, “Санамж бодлогын бичиг”, “Тоо бодлогын бичиг”, Монгол бичгийн цагаан толгой” /1924/ зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Мөн тэрээр “Монгол орны газар зүйн байдал” тусгай дэвтэр ном бичсэн бөгөөд энэ нь Б.Ринчентэй хамтарч бичсэн “Монголын газар зүйн байдал” өгүүллээс ялгаатай юм. Энэхүү зохиол нь анхан шатны сургуулиудад хэрэглэж болох сурах бичгийн чанартай бичигджээ.

1921-1930-аад онд сургуулийн сургалтанд ашиглаж болох “Ертөнцийн байдал, дэлхийн газар зүй” хэмээх 3 дэвтрийг зохиомжлон орчуулж хэвлүүлсэн бөгөөд түүнд ертөнцийн үүсэл, дэлхийн тогтоцыг дэс дараалан таниулжээ. Түмэн бодисын ухааныг хялбаршуулан сурталчлах зорилгоор Лункевичийн 40 гаруй тооны цуврал товхимолыг Ишдоржид даалган орчуулуулжээ. Өөрөө Поля Бэрагийн геометр, Бонь-егийн “Амьд байгалийн үндэс”-ийг орчуулан нийтлүүлжээ. Мөн Францын түүхч Эврегийн зохиосон “Европ, Францын түүх” хэмээх номыг орчуулж, 1-р дэвтрийг 1926 онд, 2,3-р дэвтрийг 1927 онд, 4-р дэвтрийг 1930 онд хэвлүүлсэн байна.

Ж.Цэвээн ахмад түүхч Ч.Бат-Очир, Данзан гүн зэрэг хүмүүсийн хамт судар бичгийн хүрээлэнг анхлан сэдэж байгуулсан байна. Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар Ж.Цэвээн 1921-1932 онд ажиллаж байв. Энэ хугацаанд хэвлэлтэй болох, улсын номын сан, архив, музей байгуулах, архелогич-этнографийн экспедицийн судалгаа явуулах зэрэг олон талт ажилд идэвхийлэн оролцож байжээ.

Ж.Цэвээн судалгаа, сурталчилгааны олон арван өгүүлэл, ном бүтээл бичихийн хамт монголын шинжилгээ, судалгааны ажлыг гадаадын холбогдох байгууллага, нэрт эрдэмтэдтэй холбох их ажлыг биечлэн хийжээ. Түүний нэрт эрдэмтэн академич С.Ф.Ольденбург, А.П.Карпинский, Щербатский, А.В.Обручев, П.К.Козлов, В.Л.Комаров, Б.Я.Владимирцов болон Грум Грижимайло, В.В.Бартольд, В.Л.Котвич, Н.К.Поппе, В.А.Казакевич, П.И.Рачковский зэрэг эрдэмтэдтэй холбоотой ажиллаж уйгагүй захидлаар харилцаж байсан арвин баримт материалууд бидэнд хадгалагдан үлдсэн байна.

Abstrakt: J.Tseveen is one of the important creators of the modern Mongolian science, educational system and schooling. In terms of time, his contribution to activities to education and science can be classified into two periods such as the times of *Olnoo Orgogdson Mongol Uls* (Publicly Ascended Mongolia of Bogdo Khaan) (1911-1932), and *Ardyn Zasag* (People's Government) (1921-1932).

Ашигласан ном

1. Ш.Шагдар. Монголын боловсролын түүх. УБ.,2000
2. Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. Боть I.УБ.,1997
3. Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. Боть II.УБ.,2000
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1920). УБ.,2006
5. Б.Д.Цибиков. Бурятские ученые национал-демократы. Улан-Удэ 2003
6. Д.Б.Улымжиев, Ж.Цэцэгмаа. Цыбен Жамцарано: Научная просветительская и общественно-политическая деятельность в Монголии (1911-1913гг). Улан-Удэ.1999